

“505” -ЫНХАН, ТЭДНИЙ ЭМГЭНЭЛТ ХУВЬ ТАВИЛАН

Л.Чулуунбаатар

Монгол улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх ухааны сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд дэлхийн II дайны үед эх орноосоо урвасан гэгч хэргийн учир харь газар цөлөгдөж харгислал, гэсгээн цээрлүүлэлтэнд өртсөн хуучин ЗХУ-ын А.А.Власовын армийн цэргүүдийн тухай товч авч үзнэ. Өөрчлөлт шинэчлэлтийн үйл явц өрнөх тутам болшеvizмын эсрэг тэмцэж амь насаа алдсан тэдгээр хүмүүсийг эх орноосоо урвагчид биш, баатарууд байсан гэж үнэлэх зарим дүгнэлт ОХУ-д хийгдэж буй нь уг асуудлыг нэхэн эргэцүүлэхэд хүргэсэн билээ. Манай оронд “505”-ынхныг хүнд хүчир ажилд зүтгүүлж хүний ёсноос гадуур тэдэнтэй харьцаж байсныг мэдэх хүмүүс олон байв. Түүх өнгөрсөнийг мартдаггүй, түүхийн үнэнийг олон түмэн ихэд эрхэмлэж байна.

Түлхүүр үг: Урвалт, олзлогдолт, хэлмэгдүүлэлт, гэсгээн цээрлүүлэлт, харгислал

Хүн төрөлхтөний түүхэнд олон удаа дайн болж хүн хүнээ хөнөөж, эд баялаг, эрх мэдлийн төлөө улайран тэмцэлдсээр иржээ. Өнгөрсөн XX зуунд дэлхийн II дайн гарсан. Ялангуяа 1931-1945 онд дэлхийн II дайнд олон арван сая хүний амь нас сүйдэж асар их хохирол учруулсан билээ. НҮБ-ын ЮНЕСКО-гийн дүрмэнд, дайн эхлээд хүний тархи толгойд үүсдэг гэсэн юм. “Дайн улирч балрах зүйл” боловч, өнгөрсөн үеийн гутамшигт үзэгдлийн ул мөр, гашуун сургамжийг хүмүүс ор тас мартаж чадахгүй байна. Учир нь дайн бол зөвхөн тухайн үеийн амь өрсөн ширүүн тулаан биш, олон үедээ эмгэнэлтэй гашуун сургамжийг үлдээдэг ажээ. Бас дайнаасаа дажин нь гэсэн үг ч байдаг. Энэ өгүүлэлд дайны тухай бүхэлд нь авч үзэх зорилт тавиагүй. Хуучин ЗХУ-д дайны үед эх орноосоо урвасан хэмээн яллагдаж харгислалын хатуу ширүүнийг биеэр эдэлж бараг бүгдээрээ алагдсан Власовын армийн хэлмэгдсэн цэргүүдийн тухай зарим баримтанд түшиглэн өгүүлэхийг зорьсон юм. Энэ бол туйлын эмгэнэлтэй үйл явдал байжээ. Хүнээс гадуурхагдсан тэдний талаар монголчууд мэддэг байсан төдийгүй, боломж олдвол тусалж дэмжихийг хичээж байжээ. Манай оронд хоригдож, хүнд хүчир ажилд нухлагдаж байсан тэдгээр хүмүүсийг “505”-ынхан гэж нэрлэж иржээ. Хоригдлуудын гар дээр 505 гэж шивсэн учир тийм нэртэй болжээ.

“505”-ынхны тухай саяхан болтол ер дурсдаггүй, бичиж нийтлүүлсэн зүйл ч гараагүй юм. Зөвлөлтийн цэргийн нэрт жанжин Г.К.Жуковын “Дурдатгал бодол” гэсэн II ботьд Власовын армийн тухай ер тэмдэглэгдээгүй. Харин 1950-иад оны эхээр Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд хоригдож байсан 505-ынхнаас хоёр хүн оргож

баруунд гараад, "Модотын там" гэсэн ном хэвлүүлсэн тухай дам яриа байдаг. Уг номыг олохоор багагүй сурагласан боловч лав ХБНГУ-д тийм бүтээлийн нэр тааралдахгүй байна гэж германы эрдэмтэн Удо Баркманн хэлсэн билээ. Польш, эсвэл Европын өөр улсад хэвлэгдсэнийг үгүйсгэх аргагүй юм. Власовын армийн талаар манай хүмүүсийн анх олж мэдсэн баримт нь Д.А.Волкогоновын /1/ бүтээлээс болов уу гэж бодож байна. Мөн "История отечества в документах 1917-1993 гг, часть IV, 1945-1993 гг," М; 1995г . цувралд тодорхой баримт дурдагдсан байдаг. Түүнчлэн хуучин Улсын Аюулаас Хамгаалах Хороо (КГБ)-ны архивуудаас гарсан баримтууд ОХУ-ын сэтгүүлүүд /2/-ээд нийтлэгдэж судлаачид, сонирхогчдын анхаарлыг их татаж байна. Эдгээр бүтээлүүдэд Германы зохиолч Э.Двингер, генерал Рейнхард Гелен, эрдэмтэн Йоахим Хофман зэрэг хүмүүсийн ном зохиолоос ашиглажээ. Ялангуяа И.Хофманы "Власовын армийн түүх" гэдэг номонд тухайн үеийн бодит байдлыг тодорхой өгүүлж, ямар нэгэн онол, үзэл сурталд автагдалгүй дүгнэлт хийсэн ажээ. Иймээс уг асуудлыг судлахад герман хүмүүсийн бичсэн ном болон А.Солженицыны "Архипелаг ГУЛАГ" зэрэг бүтээлийг сурвалжийн шинж чанартай хэрэглэгдэхүүн гэж үзэхэд болохгүй гэх үндэсгүй юм. Манай улсад ч "Дээдсийн амьдрал", "Сэрүүлэг" /3/ зэрэг зарим сонин хэвлэлд уг асуудалтай холбогдсон ярилцлага, тэмдэглэл нийтлэгджээ. Энэ бүхэн нь Власовын армийн тухай бодит үнэнийг олж мэдэх, нэхэн эргэцүүлэх, үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болж байна.

Хуучин ЗХУ-ын дэслэгч генерал А.А.Власовын армийн хувь заяа оровонгоороо эргэж, "505" –ынхан гэгч хоригдлууд бий болсон түүхээс товчхон сөхөж үзье.

1941-6-22 нд Германы фашистууд ЗХУ-ын эсрэг гэнэт халдан довтолсноор "Аугаа их эх орны дайн" гэж зөвлөлтийн түүхэнд тэмдэглэгдсэн дайн эхэлсэн билээ. Дайны эхний үед Зөвлөлтийн тал ихээхэн хохирол амсаж, германы цэрэг Москвагийн дэргэд тулж ирсэн. Өрнөдийн улс төрийн зарим ажиглагчид ЗХУ-ыг ердөө л гурван сар тэсэж чадна гэж үзэж байв. Нийгмийн олон түмний санаа сэтгэл ч их түгшүүртэй, хүнд байсан гэдэг. Зөвлөлтийн цэргийн нэрт жанжин Г.К.Жуков бичихдээ: "Ер нь 1942 оны зун бий болсон эвгүй байдал 1942 оны зуны кампаниар манай цэргийн ажиллах төлөвлөгөөг батлах үед өөрийн нь гаргасан хувийн алдааны үр уршиг болохыг Дээд Ерөнхий Командлагч ойлгосон гэдгийг хэлбэл зохино" / 4; 83 / гэжээ. 1942 оны эвгүй байдал гэдэг нь 7 дугаар сарын 2-ноос германы цэргийн давшилтын улмаас Воронежийн чиглэлийн байдал эрс муудаж, Волховын фронтын 2;52;59-р армиуд

бүслэгдэж хүн хүч, зэвсэг хэрэгслийн ихээхэн хохирол хүлээсэн, бас олон арван мянган цэрэг офицерууд олзлогдсонтой холбоотой байв. Дээд Ерөнхий Командлагч И.Сталины гаргасан алдаа бол дайны фронтууд дээрх армиудыг “алсын зайнаас” удирдаж, удирдлагын болон зэвсэг хэрэгслээр хангах, арми, мэргэжлийн анги нэгтгэлүүдийн харилцан дэмжлэг, уялдааг зохицуулж цагийн байдлыг оновчтой үнэлж хурдан шуурхай, шийдвэртэй байж чадаагүй зэрэгт оршиж байсан бололтой. Тэр ч байтугай архивын баримтанд тулгуурлаж бичснээс үзэхэд, “бид ерөнхий прокурор нөхөр Руденкотой Бериягийн хэргийг шүүн хэлэлцэх үед тэрээр бүр 1941 онд Сталин, Берия, Молотов нар фашист Германд ЗХУ бууж өгөх тухай асуудлыг ярилцаж, Гитлерт Зөвлөлтийн Балти орчмын улсууд, Молдави, бусад бүгд найрамдах улсуудын нутаг дэвсгэрийн хэсгийг өгөхөөр тохиролцсон гэж нотолсон” гэсэн үгийг К.С.Москаленко хэлсэн /5;172-173/ гэжээ. Энэ нь Сталиныг буруутгах гэж Бериягийн улайм цайм гүжирдсэн үг үү, үнэний хувьтай юу гэдгийг маш сайн нягтлах шаардлагатай юм.

Ер нь дайны эхэн үед Германы фашистуудын довтолгоонд ЗХУ ихээхэн хохирол үзэж хүнд байдалд орох нөхцлийг И.В.Сталины бодлого, үйл ажиллагаа бий болгосон ажээ. Учир нь ЗХУ-д 1937-1939 онд улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас цэргийн болон удирдах дадлага туршлага сайтай хүмүүсийг “ангийн дайсан”, “тагнуул”, “хуйвалдагч” хэмээн амь насыг нь хөнөөснөөс боловсон хүчний бодлого алдагдаж, нөөц, бэлтгэл хангалтгүй болсон байв. Тухайлбал, 1937 онд маршал Михайл Николаевич Тухачевскийг зөвлөлтийн эсрэг “хуйвалдаан”-ыг толгойлсон гэдэг хилс хэргээр хэлмэгдүүлсэн зэрэг олон баримтыг дурдаж болно. Мөн 1939 онд Германтай гэрээ байгуулж, түүнд ихээхэн найдаж дайсагнагч талынхаа зорилго, хүч нөөцийг дутуу үнэлсэн байв. Иймээс Германы жанжин штабаас гаргасан тооцоогоор, 1941 онд Зөвлөлтийн 3.6 сая хүн олзлогдож, улмаар 1945 оны 4 сар хүртэл нийтдээ 5160 мянган хүн олзонд байсан ажээ. Үүнийг Зөвлөлтийн тал хэтрүүлсэн тоо гэж хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд 1943 оноос зөвлөлтийн армийн цэрэг офицерууд олзлогдоогүй гэж үздэг байна.

Дайны үед үхэл, амьдралын алийг нь сонгох эгзэгтэй мөч хүнд тохиолдоход аргагүй нөхцөл байдал бас нөлөөлдөг байжээ. Энэ нь хүнд шархдах, сум хэрэгсэлгүй болох, давуу хүчинд автаж аргагүй байдалд орох, амьд үлдэхийг бодох зэрэг олон хүчин зүйлээр илэрч байсан билээ. Сталин олзлогдохыг гутамшигт зүйл төдийгүй, эх

орноосоо урвасан явдал гэж ихэд дургүйцэн ханддаг учраас Жанжин штаб болон бүх шатны удирдлагадаа хяналт хүчтэй тавьж шалгаж байхыг үүрэг болгожээ. Тэр үед “сураггүй алга болсон” хүмүүсийн жагсаалтанд завхөн 1941-1942 онд нэр бүхий 47 генерал /5;248/ орсон байв. Тэднээс Д.М.Карбышев, К.Е.Куликов С.В.Баранов зэрэг олон генерал фашистуудын бөөнөөр хорих лагерьт тамлагдаж амь үрэгджээ. Тэгвэл 1941 оны 7 дугаар сард олзлогдсон хошууч генерал П.В.Сысоев 1943 онд бөөнөөр хорих лагериас оргон зугатаж эх орондоо ирсэн боловч 3 жилийн турш “шалгагдсан” байна. 1941 оны 8 дугаар сард 12-р армийн командлагч, хошууч генерал Павел Григорьевич Понеделин бүслэлтэнд байхдаа хүнд шархдаж ухаан алдаад фашистуудад олзлогджээ. Тэр үед буюу 1941 онд ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллегийос хошууч генерал П.Г.Понеделинд эчнээгээр цаазлах ял оногдуулаад, 1945 онд чөлөөлөгдөн нутагдаа буцаж ирсний дараа баривчлан 5 жил хорьж 1950 оны 8 дугаар сарын 25-нд хоёрдахь удаагаа буудан алах ял өгч гүйцэтгэжээ. Энэ бол хүнд хичнээн энэрэлгүй, хатуу ширүүн хандаж байсны илрэл билээ.

ЗХУ-ын “Правда” сонины 1946 оны 8 дугаар сарын 2-ны дугаарт ЗСБНХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн мэдэгдэл нийтлэгдэж, түүнд А.А.Власов, В.Ф.Малышкин, Г.Н.Жиленков, М.А.Меандров, В.И.Мальцев, С.К. Буняченко, Г.А.Зверев, В.Д.Корбуков болон Н.С.Шатов нарыг эх орноосоо урваж, германы тагнуулын төлөөлөгчид болж, ЗХУ-ын эсрэг тагнан турших, хорлон сүйтгэх идэвхитэй үйл ажиллагаа явуулсан учир ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-ын 1б, 58-ын 8-11 дэх зүйлүүдэд заагдсан гэмт хэрэг өдүүлсэн гэж үзээд, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1943 оны 4 дүгээр сарын 19-ны зарлигийн I заалтын дагуу дүүжлэн алахаар заажээ. Тогтоол ёсоор гүйцэтгэсэн байна. /6; 21/. Олон жилийн турш хүмүүс энэ тухай бүх үнэнийг мэдэхгүй явж иржээ. Тухайн цаг үеийн шаардлага тийм байсан. Учрыг мэдэх цөөн хүмүүс тэдгээр “урвагчдыг” үзэн ядаж байжээ.

Бодит байдал дээр хэрэг явдал яаж өрнөсөн бэ? Власов болон власовчууд гэж хэн байв?

Зөвлөлт эх орны дайны эхний үед ЗХУ-ын армийн дээд командлалаас гаргасан оператив тактикийн алдааны улмаас германы фашистууд маш хүчтэй довтлон 1942 оны 5 дугаар сараас 7 дугаар сард баруун өмнөд чиглэл, Воронеж, Брянскийн орчмоор цөмөрч бүслэлтийн байдалд оруулжээ. Ялангуяа 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 12 хүртэл уг фронт дээр маш хүчтэй тулалдаан болж, армийн бие

бүрэлдэхүүн сум хэрэгсэлгүй, хангалт байхгүй, дэмжлэггүй, холбоо бүрэн таслагдсан ажээ. Энэ бодит байдлыг Г.К.Жуков ч өөрийн дуртгалдаа бичсэн байдаг. Тухайлбал, олон чиглэлд зэрэг давшилт хийх гэсэн буруу тактикаас дайсанд давших бололцоо өгч, хүчээ гол чиглэл рүү бөөгнөрүүлсэн боловч нэгэнт оройтсон, бас зөвлөлтийн танкын арми фронтын командлалаас ямар ч үүрэг даалгавар аваагүй, тулалдаанд орох гэж их удааширсан гэж Г.К. Жуков бичжээ. Энэ завсар Волховын фронтын цохилтын 2 дугаар арми, мөн 52, 59 дугаар армийн дайчид сум хэрэгслээ дуустал хориглон байлджээ. Эцэст нь, генерал А.А.Власовын саналаар, дайчид германы цэргүүдэд олзлогдож, өөрсдийг нь гаргуунд хаясан И.Сталин, большевизмтэй тэмцэхээр шийдсэн бололтой юм. Ер нь бодвоос эсэргүүцэн тэмцэх сум хэрэгсэлгүй олон арван мянган цэргүүд, тэдний хувь заяаны асуудал яг тэр эгзэгтэй нөхцөлд Власов байтугай, хэний ч санааг үнэхээр зовоох нь ойлгомжтой бөгөөд олзлогдохоос өөр хувилбар үнэндээ байхгүй байсан болов уу.

Дайсны бүслэлтэнд автагдсан цэрэг, армийнхантайгаа Зөвлөлтийн талаас холбоо барьж амжаагүй байтал, 6 дугаар сарын 28-нд Германы мэдээллийн товчооноос Волховын Фронтын цохилтын 2 болон 52, 59 дугаар армиудыг устгаж, 30 мянган цэрэг офицеруудыг олзолсон тухай мэлээлжээ. Энэ хуурамч мэдээлэл гэж Сталин итгэхгүй эргэлзэж байх үед “Улаан армийн цэрэг, дарга, ЗХУ-ын оросын болон бусад ард түмэнд Оросын хорооны уриалга” гэсэн Власов, Малышкин нарын гарын үсэг зурсан бичгийг Берия дамжуулжээ. Уг уриалганд, Власовын толгойлсон “Оросын чөлөөлөх арми”-ийн үйл ажиллагааг удирдах Оросын хорооны гол зорилго нь Сталин, түүний бүлгийг түлхэн унагааж, Германтай хүндэтгэлийн гэрээ байгуулан Шинэ Оросыг байгуулахад оршино. Иймээс Германтай холбоо тогтоосон Оросын чөлөөлөх армийн талд шилжин нэгдэхийг уриалсан байна.

Энэ нь сталины дэглэм өөрөө Власовынхныг төрүүлсэн гэдгийг баттай нотолж байгаа билээ. Ийм явдал гарсан нь зөвхөн сайн дураараа германчуудтай хамтран гол төлөв ухуулга сурталчилгаа, харуул хамгаалалт, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулж, малын хашаа саравч шиг байранд өлмүүн, зэлмүүн хоног өнгөрөөж байсан власовчууд төдийгүй, тэднийг төрүүлж өсгөсөн Зөвлөлт эх орны нэр хүндэд үнэхээр гутамшигтай байв. Тиймээс Власовынхныг германчууд “унтерменшен” буюу “хүнээс дор хүн” гэж үзэж, тэднийг харж хандах, хамгаалах харъяалалгүй гэдгээр нь даралт шахалт их үзүүлдэг байжээ. А.Гитлер ч тэдэнд төдий л итгэхгүй байж байгаад, дайны

сүүлчийн үе шатанд цагаан гвардчууд, янз бүрийн бүлэглэлүүдтэй хамт ашиглаж үзэхийг Гиммлерт санал болгосон байдаг. Ийнхүү 1944 оны намраас А.А.Власовын удирдсан "Оросын чөлөөлөх арми" нь 50 мянга орчим хүнтэй, Оросын ард түмнүүдийг чөлөөлөх хорооны зэвсэгт хүчин болж /7;84/, оросын "сайн дурын батальонууд" Нормандад холбоотнуудын цэргийн эсрэг вермахтын бүрэлдэхүүнд тулалдсанаас гадна Власов өөрийн 1 дүгээр дивизийг Одерын фронт дээр улаан армийн эсрэг тулалдаанд хөөж оруулжээ. /8;144/ Түүнчлэн 1945-5-5-нд Прагад германы фашистуудын эсрэг бослого гарахад Власовчууд 1 дивизийн цэргүүдээ тулалдаанд оруулж, Оросын чөлөөлөх армийн командлалын нэрийн өмнөөс С.К.Буняченко 5 дугаар сарын 7-ны үүрээр немцийн гарнизонд бууж өгөхийг тулган шаардсан байна. Энэ бол нэгд, германчуудтай зэвсэгт мөргөлдөөн хийлгүй хотод орж ирэх нөхцлийг америкчуудад олгох, хоёрт, америкчууд болон Чехийн үндэсний зөвлөлтэй хамтарч засгийн газар байгуулах боломж олж авах гэсэн зорилготой байжээ.

Гэвч юуны өмнө улс төрийн орогнол, улмаар Чехд байр сууриа тайван замаар тогтоох гэсэн Власовчуудын хүчин чармайлт бүтэлгүй болсон юм. Учир нь коммунистуудынхаа шахалтаар Чехийн үндэсний зөвлөл Власовынхантай хийсэн хэлэлцээрээр баталсан Тунхаглалыг гаргасангүй. Ийнхүү 5 дугаар сарын эхээр америкчуудын хяналтанд орсон Власовыг 5 дугаар сарын 12-нд Зөвлөлтийн талд шилжүүлэн өгчээ. Энэ нь Ялтын бага хурлаар, Гитлерийн талд байлдаж байсан хэнийг ч Зөвлөлтийн талд хүлээлгэн өгөх тухай тохиролцсон тунхаглалын дагуу болсон хэрэг байв. Харин энд нэг ойлгомжгүй нөхцөл байдал үүссэн гэдэг. Учир нь 1945 оны 5 дугаар сарын 12-ны өглөө Власов, Буняченко болон тэдний хамгийн ойрын хэд, хэдэн хүнийг америкийн хамгаалалт бүхий хуягт машины цуваа авч явах үед Якушевын тагнуулчид замд нь зогсоож, Власовыг өөрсдийн машинд шилжин суухыг санал болгоход тэрээр эрс татгалзжээ. Энэ нь зөвлөлт америкийн командлалын урьдаас тохиролцсон явууллага байсан уу, эсвэл тохиолдлоор америкчууд түүнд оргон зайлах боломж олгох гэсэн хэрэг үү гэдэг нь өнөө болтол тодорхойгүй байна. Ингээд нэг жил, гурван сарын дараа Власовынхны 12 удирдах хүн цаазлуулсан ажээ.

Власовын армийн бие бүрэлдэхүүн алаг цоог юм. Анх хүчинд автаж олзлогдсон үндсэн хэсгээс гадна Германы нутагт орогногч цагаан гвардийн генерал Красновын

удирдлаганд байсан бүлэглэл, бас украин, беларусь, гүрж, азербайжан, туркестан болон бусад үндэстний хүмүүс байжээ. Энэ армид Гиммлер нэг удаа 4000 гаруй олзлогдогсдыг шилжүүлж байсан гэдэг. Эдний дотор урвагч, олзныхон, амь зулбан зугатагсад, алуурчид, ер янз бүрийн хүмүүс байсан бололтой юм.

Власовчуудыг америкийн болон зөвлөлтийн армийн дайчид олзлон ЗХУ-д авчирсан ажээ. Тэднийг ЗХУ-ын ДЯЯ-ны 48 дугаар лагерьт төвлөрүүлж байгаад, германы армийн офицер байсан бүх хүмүүсийг офицерийн лагерьт шилжүүлжээ. Бусад хоригдлуудыг ДЯЯ-ны 505 дугаар тусгай хорих лагерьт хуваарилж онцгой чанга дэглэмд байлгажээ.

Сталины дэглэм, большевизмын эсрэг тэмцэх уриалга гаргаж, арми зохион байгуулснаар А.А.Власов хуучин ЗХУ-д ямар ч нэр хүндгүй нэгэн болсон төдийгүй, олзлогдогсод, урвагчид, элдэв төрлийн хэрэгтнүүдийг нийтэд нь власовчууд гэж нийгмээс тусгаарлан, нэн хатуу ширүүн харьцаж байжээ. Тэднээс олон хүнийг БНМАУ-д (хуучин нэрээр) цөлж, Төв, Хэнтий, Дорноговь аймагт албадан хөдөлмөр хийлгэж, алж устгаж байсан баримт олон байна. Тухайлбал, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын төвийн дэргэд Модотын хар тугалганы уурхайд Власовын армийн хоригдлуудыг яг илжиг шиг зүтгүүлж, дэндүү харгислаж байжээ. “505”-ынхныг хүнтэй уулзуулдаггүй, удаан бие засах, ядраад болон өвдвөл дор нь шууд бууддаг, машин жолоодоход хоригдлын гарыг жолоотой нь гавлаж, цуваа саатуулбал машинтай нь түлхэж, замын хажуу руу унаган булдаг, шөнө турш хоригдлуудын байрнаас хүмүүсийн орилон бархирах дуу байнга сонсогддог байсан гэнэ.

Одоо Цэнхэрмандал сумын төвд хоригдлуудын байрлаж байсан шоронгийн болон уурхайн байшингийн 1954 гэсэн бичигтэй үлдэгдэл, ганц нэг төмөр хоолой, тоног төхөөрөмж, овоолсон шороо, хиймэл нуурын хуурай хонхорхой байдаг. Мөн сумын төвөөс зүүн хойшоо 12 км газарт хоригдлуудаар дан хадан уулыг малтуулж 200м үргэлжилсэн агуй гаргуулсан байна. Үүнийг “Чонотын агуй” гэдэг. Модотын уурхай, Чонотын агуйнаас их хэмжээний шороог шууд ЗХУ руу зөөдөг байсан бөгөөд энэ нь “уран” ачигдсан ажээ. Энэ сумын төвийн ойролцоо хэсэг хэсэг овоолсон шороо байгаагийн нэлээдэд нь хоригдлууд мөнх нойрссон гэнэ. 1970 –аад оны үед манай оронд ажиллаж байсан зөвлөлтийн мэргэжилтнүүдийн ярьснаар, Цэнхэрмандалд байсан хоригдлуудын “... ихэнх нь ясаа энд тавьсан. Цөөхөн хүн нутаг буцсан. Сураг нь цааш харуулчихсан дуулдаж байсан” гэжээ. Төв аймгийн Жаргалантын сангийн аж

ахуйн ойролцоох Ногоон нуруу гэдэг ууланд 1950-иад оны үед нэг алдартай орголт болсон нь Власовын армийн хоригдлуудаас нэг офицер олон хоног олноос зугтаж бүгсэн явдал юм. Энэ офицерыг нутгийнхан "хүрэн сахалт" гэж нэрлэдэг байсан бөгөөд монгол хүмүүст гэм хийдэггүй учраас түүнд хүмүүс байнга тусалж, сайн нууцалдаг байжээ.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд, "505"-ынхан гэдэг нь зөвлөлтийн агуу их эх орны дайны үед Германчуудад олзлогдож, улмаар тэдэнтэй хамтран И.Сталин, большевизмын эсрэг тэмцэхээр зорьсон дэслэгч генерал А.А.Власовын армийнхан, ер нь зөвлөлтийн эсрэг янз бүрийн бүлэглэлийн хүмүүс байжээ. Власовынхныг сталины дэглэм өөрөө төрүүлсэн юм. Дайны үеийн хүнд хэцүү нөхцөл, бодит нөлөөлөл, давуу хүчинд автаж аргагүй байдалд байсан зэрэг хүчин зүйлийг харгалзвал олзлогдох явдал гутамшигтай боловч эх орноосоо урвасан хэрэг биш ажээ. Учир нь дайны үед олзлогдсон олон сая хүнээс нэлээд нь фашистуудын бөөнөөр хорих лагерьт амь үрэгдсэн билээ.

Фашистуудад олзлогдоод дагаар орж Власовынхан гэж нэрлэгдсэн нь 50 орчим мянган хүн байжээ. Гэтэл тэдний олонхи нь хуучин цагаан гвардийн болон янз бүрийн үндэстнүүдийн бүлэглэлийн гишүүд байсныг бодолцох хэрэгтэй. Иймээс Власовынхан гэдэг нь зөвлөлтийн эсрэг үзэлтнүүд, олзлогдогсод, урвагчид, ер нь аль муу муухай юмны "цуглуулга" байв. Хүн амьдрах эрхтэй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ёстой бол А.А.Власов, түүний талынханд хэдэн жил ийм боломж асар өндөр үнээр олдоод, эцэст нь оршин буй нийгмийн үзэл суртлын машинд няц даруулж төгсгөл болжээ. Власов, түүний талынхан бол үнэхээр эмгэнэлтэй, хөөрхийлөлтэй, хувь заяа нь хөсөр орхигдсон хүмүүс байжээ.

Энэ нь Монголд цөлөгдөж, албадан хөдөлмөр, доромжлол, гэсгээн цээрлүүлэлтэнд өртсөн "505"-ынхны бодит жишээнээс тодорхой харагддаг. Хүн хүнээ дарлан доромжлох, хүний амь юу ч биш гэдгийг Хэнтий аймгийн Цэнхэрмандалын Модотын уурхайд нухлагдаж байсан хоригдлуудтай оросууд хэрхэн харьцаж байснаар монголчууд ч сайн харж, ойлгож авсан ажээ. Тэдгээр хүмүүс бүр эхнээсээ л Сталиныг үзэн ядаж байсан уу. Армийн удирдлага, аргагүй тулгалтаас болж германы талд ажиллахаас өөр аргагүй болсон уу. Амьд үлдэх ямар нэгэн арга замыг л бодохоос өөр боломжгүй болсон уу гэх мэт олон асуулт тулгарч байна. Энэ бүх асуултанд нэгэн мөр хариулт өгөхөд бэрх. Нэлээд гүнзгий судалж, эргэцүүлэн тунгаах шаардлагатай

билээ. Урьд Власовынхныг урвагчид гээд ярих байтугай, нэрийг нь дурсахаас цэрвэж байлаа. Одоо цаг үе, нөхцөл байдал өөр болсон учраас зарим судлаачид А.А.Власовыг хамгаалж, бас үндэсний баатар гэж үзэж байна. Түүний тухайд оросын эрдэмтэд цаашид нухацтай судалж үнэлэлт дүгнэлт өгөх буй за. Власовын армийн цэргүүдээс хоригдол болж, монгол улсын нутаг дэвсгэрт өөрсдийнхөндөө тамлагдаж амь насаа алдсан эмгэнэлт явдал 60 гаруй жилийн өмнө болсон ч ахмад хүмүүс тэр аймшгийг мартаж чадахгүй, хар даран зүүдэлж байна. Хүнийг харгислана гэдгийг тэр үед оросууд нэг хэсгийгээ буруутган харийн нутагт үйлдсэн явууллагаараа нотолж өгчээ. Тэр хөөрхийлэлтэй хүмүүсээ үгүйлэх, эрж сурвалжлах ажил ч ОХУ-д явагддаггүй юм болов уу гэж бодогдож байна.

Урвагч нэр зүүж, улс орноосоо цөлөгдөж харийн нутагт хатуу ширүүн гэсгээн цээрлүүлтэнд өртсөн "505"-ынхны тухай үнэнийг дэлгэж үзэл бодлоо уралдуулан үнэлж дүгнэх цаг нь нэгэнт болжээ.

Abstract: This is a truth about the prisoners who called "505" and the terrible life of them. It said they were A.A.Blasov's Army Soldiers. The Germans took them, so they fought anti-stalin's control and anti-bolishevism. The Blasovs were the result of the Stalin's control. The Blasov's Army prisoners went through a difficult life in Mongolia and many of them died under the despotism. It depends to study about "505" It is have to study more about "505"

Ном зүй

1. Волкогонов Д. Триумф и трагедия. Политический портрет И.В.Сталина. М., 1989 тт, I-IV
2. Кудряшов С, Решин Л. Освободители - Родина, №8-9, 1992
Левин И. Генерал Власов по ту сторону линии фронта- Звезда, №6, 1995
Генерал Власов : Путь предательства. М., 1999.
Генерал Власов – предатель или герой? М., 1991
Филатов В.И. Машина смерти. М., 1995
3. З.Сэдбал. Немцүүдэд бууж өгсөн Власовын ангийнхан Монголд хоригдож тэднийг урвагчид хэмээн дэндүү харгислаж байсан. Дээдсийн амьдрал, №3 2002. Г.К.Жуков. Дуртгал бодол. II боть, УБ., 1977

4. Волкогонов. Дурдсан зохиол. II боть, I хэсэг, М., 1989.
5. История отечества в документах 1917-1993 гг. часть четвертая 1945-1993 гг. М., 1995.
6. Кудряшов С, Решин Л. Освободители – Родина, № 8, 1992
7. Левин И. Генерал Власов по ту сторону линии фронта. – Звезда, № 6, 1995
8. А.Төрбаяр . Томчууд мэргэн буучийн винтовоор чоно авладаг (Сэрүүлэг №6 2002 он)